

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Шадар сайд /Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан/-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/038/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот</p> <p>2025 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn</p> <p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn</p> <p>Аудитор: Я.Марал-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn</p>
-----------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
Т.ДОРЖХАНД ТАНАА

2025.04.25 № 1610

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Монгол Улсын Шадар сайд /Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан/-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,202.7 сая төгрөгийн 196 төсөл, арга хэмжээний 312 багц, он дамжин хэрэгжих 140,155.9 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээний 21 багц, эрх шилжсэн 323,953.9 сая төгрөгийн 53 төсөл, арга хэмжээний 96 багц, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих 371,545.9 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээний 10 багц тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 872.1 сая төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлж, 95.7 сая төгрөгийг тоног төхөөрөмж, 19.7 сая төгрөгийг тавилга, эд хогшил худалдан авах, 216.3 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, 206.2 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны “Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” 316, 800, 755 дугаар тогтоолуудын дагуу нийт 213.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, нэмж бүртгэсэн, “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 747 дугаар тогтоолын дагуу нийт 461.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон, “Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 816 дугаар тогтоолын дагуу нийт 100.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан, “Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” 749 дүгээр тогтоолын дагуу нийт 11.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор Засгийн газрын бүрэлдэхүүнд Монгол Улсын Шадар сайд, түүний харьяалалд Монополын эсрэг газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Хөрөнгө оруулалт, худалдааны газар байхаар баталсан байна.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын нэршлийг Монополын эсрэг газар болгон өөрчилж, Засгийн газрын 2024 оны 54 дүгээр тогтоолоор газрын дүрмийг шинэчлэн баталсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 2 хөтөлбөр, 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас биелэлт 43.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.0	36,018.3
33	АВЛАГА	0.0	960.2
34	УРЬДЧИЛГАА	0.0	939.5
35	БАРАА МАТЕРИАЛ	0.0	34,118.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.0	3,843,545.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.0	3,843,545.0
39200	Биет хөрөнгө	0.0	1,365,245.2
39300	Биет бус хөрөнгө	0.0	2,478,229.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.0	3,879,563.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	672.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	672.0
41300	Өглөг	0.0	672.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.0	3,878,891.3
51	Засгийн газрын хувь оролцоо	0.0	3,878,891.3
51200	Хуримтлагдсан үр дүн	0.0	3,878,891.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.0	3,879,563.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.0	9,985,175.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.0	4,033,044.1
120	Нийтлэг татварын бус орлого	0.0	4,033,044.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.0	5,952,131.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.0	6,077,039.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.0	6,077,039.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.0	4,795,925.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.0	2,883,445.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	375,863.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0	256,617.4
2104	Хангамж, бараа материалын зардал	0.0	140,036.0
2105	Нормативт зардал	0.0	2,427.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	13,600.5
2107	Томилот, зочны зардал	0.0	34,784.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.0	684,213.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	404,937.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	1,281,113.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0.0	3,908,136.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	29,245.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	0.0	3,878,891.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0.0	5,977,268.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.0	25,137.1
120	Нийтлэг татварын бус орлого	0.0	25,137.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.0	5,952,131.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.0	5,669,150.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.0	5,669,150.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.0	4,387,453.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.0	2,875,131.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	378,535.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0	256,617.4
2104	Хангамж, бараа материалын зардал	0.0	91,966.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	23,541.8
2107	Томилолт, зочны зардал	0.0	31,784.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.0	727,977.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	1,899.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	1,281,696.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.0	308,118.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.0	308,118.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	308,118.3
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	308,118.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.0	(308,118.3)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	0.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	0.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.0	0.0
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
17	Тайлант үеийн үр дүн	3,878,891.3	3,878,891.3
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,878,891.3	3,878,891.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,143,107,900.00	4,396,934,592.45	746,173,307.55	85.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,143,107,900.00	4,396,934,592.45	746,173,307.55	85.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,107,324,000.00	4,363,670,092.45	743,653,907.55	85.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,494,903,100.00	2,875,131,203.29	619,771,896.71	82.3
210101	Үндсэн цалин	2,028,011,000.00	1,757,877,266.24	270,133,733.76	86.7
210102	Нэмэгдэл	951,106,700.00	534,793,762.74	416,312,937.26	56.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	382,648,800.00	370,552,247.01	12,096,552.99	96.8
210104	Урамшуулал	132,587,500.00	211,907,927.30	(79,320,427.30)	159.8
210105	Гэрээт ажлын хөлс	549,100.00		549,100.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	450,862,900.00	378,535,588.85	72,327,311.15	84.0
210201	Тэтгэврийн даатгал	306,586,700.00	261,071,621.33	45,515,078.67	85.2
210202	Тэтгэмжийн даатгал	36,069,000.00	28,972,138.75	7,096,861.25	80.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,034,400.00	15,869,942.19	2,164,457.81	88.0
210204	Ажилгүйдлийн даатгал	18,034,700.00	14,524,437.35	3,510,262.65	80.5
210205	Эрүүл мэндийн даатгал	72,138,100.00	58,097,449.23	14,040,650.77	80.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	256,994,800.00	256,617,370.00	377,430.00	99.9
210301	Гэрэл, цахилгаан	229,100.00		229,100.00	
210304	Байрны түрээс	256,765,700.00	256,617,370.00	148,330.00	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	92,058,400.00	91,966,865.23	91,534.77	99.9
210401	Бичиг хэрэг	20,763,600.00	21,150,110.00	(386,510.00)	101.9
210402	Тээвэр, шатахуун	11,468,200.00	7,000,000.00	4,468,200.00	61.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	46,464,900.00	50,216,122.23	(3,751,222.23)	108.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ажлын эд зүйлс	13,361,700.00	13,600,633.00	(238,933.00)	101.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,010,200.00	71,981,600.00	28,600.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,982,700.00	51,558,200.00	(575,500.00)	101.1
210604	Урсгал засвар	21,027,500.00	20,423,400.00	604,100.00	97.1
2107	Томилолт, зочны зардал	32,029,100.00	31,784,242.00	244,858.00	99.2
210701	Гадаад албан томилолт	22,040,600.00	21,989,242.00	51,358.00	99.8
210702	Дотоод албан томилолт	9,988,500.00	9,795,000.00	193,500.00	98.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	705,622,700.00	655,754,223.08	49,868,476.92	92.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	655,506,100.00	607,677,170.08	47,828,929.92	92.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,459,500.00	2,000,000.00	459,500.00	81.3
210803	Даатгалын үйлчилгээ	8,800,700.00	8,748,000.00	52,700.00	99.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	406,000.00	49,200.00	356,800.00	12.1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	53,800.00		53,800.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,990,300.00	36,984,899.00	1,005,401.00	97.4
210807	Газрын төлбөр	406,300.00	294,954.00	111,346.00	72.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,842,800.00	1,899,000.00	943,800.00	66.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,842,800.00	1,899,000.00	943,800.00	66.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,783,900.00	33,264,500.00	2,519,400.00	93.0

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,172,900.00		1,172,900.00	
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,172,900.00		1,172,900.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,611,000.00	33,264,500.00	1,346,500.00	96.1
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	32,110,000.00	31,298,000.00	812,000.00	97.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,501,000.00	1,966,500.00	534,500.00	78.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,143,107,900.00	4,396,934,592.45	746,173,307.55	85.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,118,107,900.00	4,371,797,476.15	746,310,423.85	85.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,118,107,900.00	4,371,797,476.15	746,310,423.85	85.4
20004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,000,000.00	25,137,116.30	(137,116.30)	100.5
200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,000,000.00	25,137,116.30	(137,116.30)	100.5
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1	0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	0	100.0
610001	Төсвийн байгууллага	3	3	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	120	90	30	75.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		872,123,882.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		872,123,882.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		331,902,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		115,544,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		95,750,000.00
210602	Тавилга		19,794,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		216,358,060.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		194,907,784.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		21,450,276.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		540,221,822.50
2132	Бусад урсгал шилжүүлэг		206,258,724.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		206,258,724.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		872,123,882.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		872,123,882.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		149,010,784.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		723,113,098.50

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 377.9 сая төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	ТЕЗ	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
									Үүнээс			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	МУШС /ГХХО/	Төрийн худалдан авах ажиллагааны газар	1	333,826.0			1	333,826.0	1	333,826.0		
2	МУШС /ГХХО/	Төрийн худалдан авах ажиллагааны газар	1	182.6			1	182.6	1	182.6		
3	МУШС /ГХХО/	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	1	14,216.6			1	14,216.6	1	14,216.6		
4	МУШС /ГХХО/	Монополын эсрэг газар	1	29,750.0	1	29,750.0			1	29,750.0		
Нийт			4	377,975.2	1	29,750.0	3	348,225.2	4	377,975.2		

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3.2 Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 64.5 сая төгрөгийн 9 зөрчил илэрч, 0.9 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 34.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлж, 29.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж хүргүүлсэн

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	ТЕЗ	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт санхүүгийн зөрчил		Санхүүгийн зөрчил Үүнээс											
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хуулийн байгууллагад шилжүүлэх			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	МУШС /ГХХО/	Монгол Улсын Шадар сайд-ТЕЗ	1	0					1	0						
2	МУШС /ГХХО/	Төрийн худалдан авах ажиллагааны газар	1	20,000.0					1	20,000.0						
3	МУШС /ГХХО/	Төрийн худалдан авах ажиллагааны газар	1	1,200.0					1	1,200.0						
4	МУШС /ГХХО/	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	1	939.4	1	939.4										
5	МУШС /ГХХО/	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	1	0			1	0								
6	МУШС /ГХХО/	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	1	617.0					1	617.0						
7	МУШС /ГХХО/	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	1	6,800.0					1	6,800.0						
8	МУШС /ГХХО/	Монополын эсрэг газар	1	34,000.0			1	34,000.0								
9	МУШС /ГХХО/	Монополын эсрэг газар	1	1,015.2					1	1,015.2						
НИЙТ			9	64,571.6	1	939.4	2	34,000.0	6	29,632.2	0	0	0	0	0	0

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудиттай холбоотой зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	ТЭЗ	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хуулийн байгууллагад шилжүүлэх	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	мөнгөн дүн	Тоо
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой															
1	МУШС /ГХХО/	Монгол Улсын Шадар сайд-ТЭЗ	1	0					1	0					
2	МУШС /ГХХО/	Төрийн худалдан авах ажиллагааны газар	1	0					1	0					
3	МУШС /ГХХО/	Төрийн худалдан авах ажиллагааны газар	1	0					1	0					
4	МУШС /ГХХО/	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	1	0					1	0					
5	МУШС /ГХХО/	Монополын эсрэг газар	1	18,300.0					1	18,300.0					
НИЙТ			5	18,300.0					5	18,300.0					